

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3646>

Article | Fasc.25

“Урлагийн боловсрол” ойлголтыг тодруулах судалгааны зарим үр дүн

Тогтохбаярын Эрдэнэтуяа

Чингис хаан үндэсний музей, Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0009-0008-6808-3056>
Холбоо барих зохиогч: tuyartist@gmail.com

Хураангуй: Урлагийн нийгэмд гүйцэтгэх үүргийн томоохон хэсэг нь олон нийтийн соёл гэгээрлийн ажил байдаг. Гэвч урлагийн боловсрол гэх ойлголт нийтэд хэрхэн түгсэн, түүнийг хэрхэн зөвөөр хүлээн авч, нэгдмэл ойлголтод хүрсэн нь тун эргэлзээтэй ба үүнийг тодруулах шаардлагын үндсэн дээр Улаанбаатар хотоос Соёлын дээд сургуулийн багш нар, СӨБ 164-р цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд, ЕБ-ын Олонлог Эгээ сургуулийн багш, эцэг эхчүүд, төрийн албан хаагчид болон СУИС-ийн эрдэмтэн судлаач, судлаач оюутнууд, эрдэм шинжилгээний ажилтнууд зэрэг төлөөллүүдийг оролцуулан нийт 231 хүнээс 5 асуулгатай судалгааг авсан. Судалгааг зөвхөн хэрхэн ойлгогдож байгаа нэр томъёоны ойлголтоор хязгаарлав. Мөн судлаачид болон багш нарын ойлголтын хүрээг шинжлэн тодорхойлох зорилго тавив. Дэлхий нийтэд түгсэн урлагийн боловсролын тогтсон ойлголтыг тодруулах, монголд буй ойлголтыг харьцуулахыг гол болгов. Судалгааг социологийн суурь түвшний нэлэнхүйн судалгааны аргаар авсан ба SPSS программыг ашиглан үр дүнг боловсруулж, дүгнэлт гаргахдаа урлагийн боловсролын шалгуур үзүүлэлт болох гоо зүйн төлөвшил, системтэй олгох боловсрол гэсэн асуулуудыг оруулсан бөгөөд судалгаанд оролцогчдын ихэнх нь урлагийн боловсролын тухай ойлголтыг зөвөөр ойлгодог болох нь харагдаж байна.

Түлхүүр үгс: *урлагийн боловсрол-ухагдахуун, олон нийтийн ойлголтын судалгаа*

Some results of research clarifying on the concept of “Art Education”

Erdenetuya Togtokhbayar

“Chingis Khaan” National Museum, Ulaanbaatar, Mongolia
ORCID: <https://orcid.org/0009-0008-6808-3056>
Corresponding author: tuyartist@gmail.com

Abstract: One of the roles of art in society is cultural enlightenment. However, it is very doubtful how the concept of art education spread to the public, how it was received correctly, and how a unified understanding was reached. In research included representatives of parents, teachers, the high school of Olonlog Egze, academicians,

Received: 2024.03.31/ Accepted: 2024.07.22

© Author (s). 2024



research students, and Mongolian Arts And Culture University's students and teachers from Ulanbator. The study was limited to the concept of how the term is understood. It was also aimed to analyze and determine the framework of understanding of researchers and teachers. The focus is on clarifying the established concepts of art education spread around the world and comparing the concepts in Mongolia. The research was carried out by the method of basic sociological research, and the SPSS program was used to process the results and conclusions, including questions about aesthetic development and systematic education, which are indicators of art education.

As a result of research, It appears that the concept is understood correctly in public.

Keywords: *concept of art education, research of public understanding*

Судалгааны арга зүй

Бидний судалгаанд урлагийн боловсрол ойлголтыг тодруулахын үндсэн дээр зөвхөн суурь асуулгыг 4 хүчин зүйлийн хамгийн суурь түвшин болох гоозүйн төлөвшлийн байдлыг оруулж өгсөн. Урлагийн боловсрол ойлголтын магадлан таамаглалыг судлахын үндсэн дээр судалгааг боловсролын байгууллагын төлөөлөл болох багш, судлаач, олон нийтийн төлөөлөл болох эцэг эх гэсэн социологийн тоон аргад суурилсан нэлэнхүйн судалгаа авсан. Соёлын дээд сургуулийн багш нар, СӨБ 164-р цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд, ЕБ Олонлог Эгзе сургуулийн багш, эцэг эхчүүд, коллеж, төрийн албан хаагчид болон СУИС эрдэмтэн судлаач, судлаач оюутнууд, эрдэм шинжилгээний ажилтнууд зэрэг төлөөллүүдийг оролцуулсан. Судалгааг зөвхөн нэр томъёоны ойлголтын хэвшмэл чанарыг болон концепцийн ойлголтыг чухалчлан онцолсон.

Судалгааг социологийн суурь түвшний нэлэнхүйн судалгааны аргаар авсан ба SPSS програмыг ашиглан үр дүнг боловсруулж, дүгнэлт гаргахдаа урлагийн боловсролын шалгуур үзүүлэлт болох гоо зүйн төлөвшил, системтэй олгох боловсрол гэсэн асуулгуудыг оруулж өгснийг дүн шинжилгээ хийсэн. Бидний таамаглалаар хүн амын урлагийн боловсролд хандах хандлага ойлголт дутмаг ба олон нийтээс тусдаа, тусгай ойлголт хэмээн ойлгодог 2-р түвшний ойлголтоор ойлгож байгаа хэмээн дэвшүүлсэн.

Урлагийн боловсролын тухай ойлголтын онолын судалгаа болон түүхэн үйл явдлыг баримт бичиг судлалын аргаар судалж, шинжилсэн.

Судалгааны үр дүн

Хэн ямар мэргэжилтэй байх нь чухал биш, гол нь боловсролтой, боловсорсон өндөр моральтай хүн байх нь ирээдүйн дэлхийн иргэний шаардлагад нийцнэ. Эдгээр чанарын суурийг урлагийн боловсролоор олгох бүрэн боломжтой. Хүүхэд бүр урлагтай холбогдох нь хүний байгалиас заяасан үндсэн хэрэгцээний асуудал ба эрүүл нийгмийн эхлэл (Angel E 1970) хэмээн үндсэн суурь хэрэгцээний түвшинд урлагийн боловсролыг авч үзсэнээр шинэ цагийн урлагийн боловсролын тодорхойлох суурь ойлголт болно. Дэлхий дахинд урлагийн боловсролын ойлголт ХХ зуунаас эхлэн яригдсан ба олон нийт, хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй олгох тухай үзэл баримтлал юм. “Урлагийн боловсрол /Art Education/” нэр томъёог хамгийн анх гаргаж ирснээр АНУ-ын философич, сэтгэл судлаач Жон Дэвэй (John

Dewey) “Урлаг туршлага болох нь” (Art as Experience) (1934), Е.Н.Гомрич “The Story of Art” (1950) гэх мэт суурь бүтээлүүд бичигдсэн нь олон нийтэд урлагийг өөр өнцгөөс харах үндэс болов. Үүний улмаас хэт тусдаа байсан ойлголт задарч, боловсролын системийг өөр өнцгөөр харах боломжтой болж, урлагийг олон нийтэд ойртуулах ажлыг хийж эхэлсэн.

Монгол оронд энэ талаар 1990 оноос эхлэн яригдсан боловч чухам юуг урлагийн боловсрол хэмээн ойлгодог болон түгээх арга барил, системийн асуудлыг эргэн харж, цэгцлэх шаардлага бидний өмнө тулгарч байна.

“Урлагийн боловсрол” ухагдахуун үүсэхэд (урьд өмнө зөвхөн ордонд байх ёстой тусгай хүмүүст зориулсан гэх ойлголтыг халахад) философийн нөлөөлөл болох хүмүүнлэгийн салбар (Brestler 2007) чухал түлхэц болсон. Философийн экзистенциалист урсгал нь “Урлагийн боловсрол” ухагдахуунд зохих нөлөө үзүүлж, хүний суурь хэрэгцээнд тулгуурлан төлөвших ёстой гэсэн ойлголтыг өрнөдийн нийгэмд улам бүр түгээсэн. Гэвч өмнөх зуунуудад урлагийн боловсролыг зөвхөн тодорхой хүрээнд хүргэх ёстой гэж үзэж байсан (Arthur D Efland 1990). Урлагийн боловсрол нь урлагийн нэгдсэн системийн багахан хэсэг бөгөөд олон нийтэд хамаатай ойлголтуудыг хамааруулан авч үздэг. Энэхүү ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, зөв төлөвшүүлэхэд үндсэн суурь нөхцөл чухал байдаг.

Орчин цагийн хүмүүнлэгт чиглэсэн урлагийн боловсролыг тодорхойлоход 3 хүчин зүйлийн нөлөө байх ба нэгдүгээрт, байгаль болон уламжлал, хоёрдугаарт, философи, гуравдугаарт, боловсролын сэтгэл судлал (Gaitskell Charles D 1958) гэж үзсэн нь боловсролын сэтгэл судлал салбарын нөлөө их байгааг харуулж байна. Урлагийн боловсрол нь сонсгол, хүрэлцэх, үнэрлэх мэдрэхүй дээр тулгуурлан явагддаг хэмээн таван мэдрэхүйн хэлэмж дээр тулгуурлах ач холбогдолтойг мөн дурдсан байдаг.

Урлагийн философи нь гоо зүй, соёлын философийн ерөнхий ойлголтуудын хүрээнд урлагийн мөн чанар, учир шалтгааныг судалж, философийн өөрийнх нь төдийгүй уран бүтээлийн үндсэн зарчмуудыг тодорхойлж байдаг (Ариунаа 2018). Хүмүүнлэг боловсролын мөн чанар нь бусад бүх юмнаас, түүний дотор өөрийн уг болох амьтнаас ялгарах хүний эрхэм чанарын үүднээс шинжлэх ухааны ба амьдрах ухааны боловсролын харилцан үйлчлэл шүтэн барилдахуйн суурь үндсэн үнэлэмж, арга хэрэгслийн иж бүрдэлд оршино. Хүмүүнлэг боловсрол явцуу утгаараа хүмүүнлэгийн ухаанууд буюу хэл, соёл урлаг, уран зохиол, сэтгэлгээ, хүн хоорондын харилцааны үнэт зүйлсийг хүүхдэд эзэмшүүлэх хүрээний боловсролыг хэлнэ (Ган-Өлзий 2022).

Урлагийн боловсролд чухал яригдах ёстой хүмүүнлэг боловсролын мөн чанар болон түүнийгээ дагасан боловсролын ёс зүйн чанарын асуудал чухал. Боловсролын ёс зүй нь албан, албан бус, тасралтгүй боловсролын тогтолцоон дахь сурч, хүмүүжихийн төлөөх оролцогчид хоорондын ёс суртахууны зан үйлийн дүр төрх, дадал зуршил, байр суурь, үнэлэмжийг авч үздэг. Өөрөөр хэлбэл, багш ба суралцагчдын ёс суртахууны хэм хэмжээ, чин эрмэлзлэл нь уг төрхөөрөө болон уламжлал, шинэчлэлийн явцад нийгэм, хувь хүний хөгжил төлөвшлийн байдалд хэрхэн илэрч, төгөлдөржиж буйг судална (Пүрэв 2022).

Урлагийн боловсрол гэдэг нь дүрслэх болон биет урлагт суурилсан

системтэйгээр заах аргачлалыг хэлдэг ба бүжиг хөгжим, жүжиг, драм, дүрслэх урлагийн төрлүүд ордог.

Урлагийн боловсролын ач тусыг хүний нийгмээс олж авсан хүмүүжлийн сууринаас илүүтэй төрмөл биологийн хүчин зүйлийн үндсэн суурин дээр авч үздэг. Хүн байгалиасаа бүтээлч байдалтай төрдөг нь “Бүтээлч чадварын хөгжил” гэх ойлголт бөгөөд бидний ихэнх нь бүтээлч чадвартай төрсөн, үүнийг урлагийн боловсролоор бага балчраас нь хөгжүүлэх чухал гэх үзэл баримтлах явдал юм.



Зураг 1. Урлагийн боловсролын хүчин зүйлс

Ингэснээр аливааг зүйлийг хүлээн авах, танин мэдүүлэх зүй тогтол харилцаа холбоо, шийдвэр гаргах, юмсыг ангилах талаар сэтгэлгээ хөгжих ба амьдралын турш энэхүү үзэл бодол төлөвшиж, амьдралын чанартай гоозүйг олж авах, өөрийгөө нийгэмд зөвөөр илэрхийлэх ухамсрыг нэмэгдүүлж, байгаа зүйлийг байгаагаар нь хүлээн авах, дасан зохицох чадвар нь цаашид зөв хөгжих үндэс болдог. Урлагийн боловсролын хүрээнд хүрээлэн буй орчин, байгаль дэлхийг зөв зүйтэй мэдэрч харилцах чадварыг дээшлүүлэх гоозүйн болон дизайны мэдлэгийг олж авахаас гадна урлагийн мэдрэмжийг дээшлүүлсний үр дүнд бодит болон хийсвэр зүйлсийг тэнцвэржүүлэн хүлээн авах, сэтгэцийн тэнцвэрт байдлыг хангах чадвартай болно.

Барууны орнуудын бага ангийн хөтөлбөрт зураг болон хөгжмийн боловсролыг чухалд үзэх боловч математикийн хичээл, эдийн засгийн агуулга бүхий хичээлүүдийг бодвол ач холбогдлыг нь доогуур үнэлсээр байна (Vojislav Ilic 2017).

Боловсрол судлалын асуудалд урлагийн боловсролыг оруулж үзэхийн чухлыг урлаг бол боловсролын хамгийн том зорилго бөгөөд мэдрэмж зөн совин, зохицол, тэдгээрийн бүрэн бүтэн байдал (Shectman Angel E 1970) хэмээн дурдсан байдлыг авч үзвэл зөвхөн рационал сэтгэлгээний илрэл болох мэдлэг мэдээллийг урлагийн боловсролоор тэнцвэржүүлэх эрүүл сэтгэцтэй бие хүн бүрэлдэх нөхцөл болж байна.

Хүн төрөлхтний боловсрол олгох зарчим, суурь ойлголтууд улам бүр өөрчлөгдсөөр байгаагийн илрэл нь хүн өөрөө өөртэйгөө танилцан, тархи судлал болон харьцангуй залуу шинжлэх ухаан болох сэтгэлзүйн үндсийг чухлаар тавих болсон. Зөв бие хүнийг төлөвшүүлсэн ирээдүйн чанартай иргэнийг сургахад нялх үеэс, сууринаас хүмүүнлэгт чиглэсэн боловсролын тогтолцоо яригдах

болсны үндсэн дээр хүн төрөлхтний олон зуун жил алдаж ирсэн алдаа онооны нөхөөс болсон нейро шинжлэх ухаан гарч ирсэн. Энэ нь урлагийн боловсролыг бид системтэйгээр эрт үед (0-3 насанд) хүний тархины онцлогт тулгуурласан, сэтгэлзүйн суурь зарчмыг үндэстэй олгох боломжтой гэсэн тогтолцоо юм.

Урлагийн боловсролыг орчин үед харах хандлага, бүтээлч байдал, соёлын ухамсар, академик мэдлэгийн сайжрал, хүүхдийн бие физиологийн булчингийн хөгжил, харааны тогтоолт, асуудлыг шийдвэрлэх чадвар, шийдвэр гаргалт, тэвчээр хатуужил, олон нийтийн төлөвшил буюу хамтрах, хариуцлагын чадвар зэрэг чадварыг хөгжүүлдэг хэмээн үзэж байгаа бөгөөд гоо сайхны боловсрол нь хүн байгаль, нийгмийн гоо сайхныг мэдэрч, үнэлэх, гоо сайхны хуулиар орчноо өөрчлөх хүсэл, эрмэлзэлтэй, чадвартай бие хүн төлөвшихөд нөлөөлөх зорилго чиглэлтэй үйл явц (Даваа 2015) юм.

Монгол оронд мэргэжлийн урлагийн сургуулиуд байдаг ч гэсэн олон нийтэд зориулсан хүүхэд бүрт хүрч ажиллах урлагийн боловсролын ойлголт хараахан байгаагүй нь нотлогдож байна. 1921 оны 11-р сарын 2-нд нийслэл хүрээнд ардын засгийн анхны бага сургууль нээгдсэнээр дүрслэх урлагийн боловсролын тогтолцооны эх тавигдсан боловч төдийлөн утга агуулгад бүрэн нийцээгүй байдалтай явагдаж байгаад 1970-аад оноос зургийн хичээл нь зөвхөн зураг зуруулах хичээл бус дүрслэх урлагийн боловсрол олгох хичээл хэмээн үзсэн байна. 1990 оноос манай боловсролын систем шинэ нийгмийн үзэл санаа, бүтэц, тогтолцоог дагаад үндсээрээ өөрчлөгдсөн. XXI зуун гарснаар дэлхийн түвшний сургалт явуулахын тулд боловсролын стандартыг шинэчлэн мөрдөх шаардлага гарчээ (Даваапил 2013). Энэ үед урлагийн боловсролын ойлголт төдийлөн хэлбэржээгүй байсан боловч дэвшилтэт шийдэл болох дүрслэх урлагийн бүтээлийг илүү нарийн ойлгох, түүнийг тайлбарлах, өөрийн өнцгөөс илэрхийлэх “дүрслэх урлагийн ярианы хичээл”-ийг оруулах болсон. 1960 оноос хойш урлагийн бүтээл судлуулах ажлын жинг нэмэгдүүлсээр 1970 оны эхээр сургалтад нэвтрүүлсэн байна. Ингээд агуулгын хүрээ тэлж хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт орсноор “Зургийн хичээл”-ийн нэрийг “Дүрслэх урлаг” болгон өөрчлөхөд хүрчээ (Даваапил 2018). Үүнээс харахад дүрслэх урлагийн тайлбар гэдэг маш нарийн ойлголт бөгөөд үүнийг урлагийн боловсролд нэвтрүүлэх анхдагч суурийг тавих оролдлого “дүрслэх урлагийн ярианы хичээл”-ээр тавигдсан. Дүрслэх урлагийг тайлбарлах хичээлийн хөтөлбөрийн зарчим нь олон тооны өөр өөр өнцгийн тайлбар тухайн бүтээлийг харах өнцгийг баяжуулаад зогсохгүй мөн өөр өөр бодол сэдлийг төрүүлэх ач холбогдолтой (Terry Barret 2000).

Монголын соёл судлаачдын дүгнэлтээс үзвэл, Монгол Улс соёл урлагийн боловсролын хувьд чамгүй сайн боловсруулсан бодлоготойд тооцогддог ажээ (Глоб Интернетшл ТТБ 2004). Глоб Интернетшл ТББ, Нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын сан)-гийн тусламжтай 2003 онд “Урлагийн боловсрол” анхан шатны судалгааг монголын урлагийн боловсролын түвшинг судалж, цаашид сайжруулах арга замд тус дөхөм болох саналыг дэвшүүлэх зорилгоор авсан. Урлагийн тухай мэдлэг мэдээллийг (80%) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонин, ФМ радио, ТВ, гол төлөв хөгжмийн нэвтрүүлэг, киноноос авдаг хэмээн хариулсан нь бидэнд үнэхээр системтэй урлагийн боловсрол дутмаг, хангалтгүй гэдэг нь харагдаж байжээ. Харин

энэхүү судалгааны үр дүнг өнөө цагт буюу 21 жилийн дараа өөрийн судалгаатай харьцуулан, нийгэмд урлагийн боловсролын ойлголт хэр хандлагатай болсон болон хэр түгсэн болохыг тодорхойлохыг оролдлоо.

Нийтлэг байдлыг харгалзан үзвэл, 1990-ээд оноос хойш байгуулагдсан байгууллагын стратегид “үзэгчдийн урлагийн боловсрол” гэсэн үг ухагдахуун ямар нэг байдлаар тусгагдсан байна. Харин үүнээс өмнө байгуулагдсан байгууллагын стратегид урлагийн боловсролын асуудал өнөөгийнхөө зохих утгыг агуулж чадаагүй байгаа тал ажиглагдаж байна (Глоб Интернетшнл ТТБ 2004). Урлагийн боловсролын ойлголт хүүхэд бүрт хөгжүүлэх ёстой суурь ойлголт байдаг боловч ихэвчлэн ямар нэг дугуйлан секцэнд хамруулж байж урлагийн боловсрол авах тусдаа ойлголт хэмээх ойлголт газар авсан.

Хүн ард, хүүхэд залуучуудыг гоо зүйн хүмүүжлээр хүмүүжүүлэх нь чухал болохыг социалист нийгмийн үед хэвлэгдэн гарч байсан гоо зүйн ном, сурах бичгүүдэд их онцлон бичсэн байдаг. Түүхээс үзвэл, ХҮШ-ХІХ зууны үеэс Лувсанчүлтэм, Данзанравжаа, Инжиннаш зэрэг монголын сэтгэгчид өөрсдийн уран бүтээлээрээ дамжуулан гоо сайхны үзэл санаагаа илэрхийлэн гаргаж байсан юм. Европын шинжлэх ухааны төвшинд ХХ зууны 2-р хагасаас эхлэн монголд гоо зүйн шинжлэх ухаан хөгжсөн (Дэлгэрмаа 2022).


Маш энгийн өдөр тутмын аргаар хүүхэд бүрт урлагийн боловсролын элементийг зааж сургах боломжтой байдгийг дурдах нь зүй. Монгол оронд урлагийн боловсролын ойлголтыг нийт 3 түвшний ойлголтоос (1-р түвшин хараахан биежээгүй ойлголт, 2-р түвшин олон нийтээс тусдаа ойлголт, 3-р түвшин хүнд байх ёстой зайлшгүй чанар) 2-р түвшний буюу олон нийтээс тусдаа ангид ойлголт хэмээн ойлгогдож байгаа эхний таамаглалыг батлахыг зорьж судалгааг хийсэн.

Урлагийн боловсрол ойлголтыг нийгэмд хэрхэн ойлгож хүлээж авч байгаа хандлага, түүнийг тодорхойлж цаашдын эрэлт хэрэгцээг тодруулах зорилготойгоор түүврийн аргаар судалгаа авсан ба нийт 231 хүн судалгаанд оролцсон бөгөөд статистик дүнгээр эцэг эхийн төлөөлөл 105 (45%), багш 74 (32%), судлаач 52 (22,5%) хүн тус тус оролцлоо.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын тоо

| № | Бүлэг | Хүний тоо | Хувь |
|---|----------|-----------|--------|
| 1 | Багш | 74 | 32% |
| 2 | Эцэг, эх | 105 | 45,5% |
| 3 | Судлаач | 52 | 22,5% |
| 4 | Нийт | 231 | 100.0% |

Урлагийн боловсролын талаар ойлголтыг 77,9% мэднэ, 17,3% мэдэхгүй, 4,8% сонсож байгаагүй гэж хариулжээ.




Зураг 2. Та урлагийн боловсролын талаар хэр мэдэх вэ? асуулганд хариулсан байдал

Хүснэгт 2. Урлагийн боловсрол гэж таны ойлголтоор юуг хэлдэг вэ?

| № | Асуулга | Давтамж | Хувь | Хувийн чанар |
|---|---|---------|--------|--------------|
| 1 | Хүн бүрт байх ёстой гоо зүйн төлөвшил | 134 | 58% | 58% |
| 2 | Олон нийтэд хамаагүй тусдаа ойлголт (урлагийн хүн) | 18 | 7,8% | 7,8% |
| 3 | Хүүхэд бүрт зориулсан системтэй хөгжүүлэх боловсрол | 60 | 26,0% | 26,0% |
| 4 | Мэдэхгүй | 19 | 8,2% | 8,2% |
| 5 | Нийт | 231 | 100.0% | 100.0% |

Урлагийн боловсролын тухай ойлголтыг судалсан судалгаанаас харахад хамгийн их буюу 58% нь хүн бүрт байх ёстой гоозүйн төлөвшил хэмээн үзсэн бол хүүхэд бүрт зориулсан системтэй хөгжүүлэх боловсрол 26%, олон нийтэд хамаагүй тусдаа ойлголт 7,8%, мэдэхгүй гэж хариулсан нь 8,2%-г эзэлж байна.



Зураг 3. Та болон таны (ойр орчмын хүмүүс) өмнө нь ямар нэг урлагийн боловсрол олгох хөтөлбөрт хамрагдаж байсан уу?

Судалгаанд оролцсон төлөөлөл болох багш, эцэг эх, судлаач нараас та болон таны эргэн тойрны хүмүүс ямар нэгэн урлагийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж байсан эсэхийг тодруулахад 47% нь тийм, 53% нь үгүй гэсэн хариулт өгснөөс харахад тийм, үгүй хариултын харьцаа хол зөрүүгүй байгаа нь үйл ажиллагаанд ямар нэг байдлаар хамрагдаж байсан байна.

Хүснэгт 3. Урлагийн боловсролын хөтөлбөрт хүүхдээ системтэй хамруулах хэрэгцээ таньд байгаа юу?

| № | Хариулт | Хүний тоо | Хувь |
|---|-------------|-----------|--------|
| 1 | Байгаа | 178 | 77% |
| 2 | Байхгүй | 29 | 12,6% |
| 3 | Мэдэхгүй | 24 | 10,4% |
| | Нийт | 231 | 100.0% |

Судалгаанд урлагийн боловсролын хөтөлбөрт системтэй хамруулах хэрэгцээ нийт 231 хүнээс 178 нь буюу 77% нь хэрэгцээ шаардлагатай байгаа гэснийг үзэхэд олон нийтэд маш хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4. Урлагийн боловсролын талаарх мэдлэг, мэдээлэл олон нийтэд хэр хэрэгтэй гэж үзэж байна?

| № | Асуулга | Хүний тоо | Хувь | Нийт хувь |
|---|------------------|-----------|--------|-----------|
| 1 | Маш их хэрэгтэй | 135 | 58,4% | 58,4% |
| 2 | Хэрэгтэй | 73 | 31,6% | 31,6% |
| 3 | Хэрэггүй | 9 | 3,9% | 3,9% |
| 4 | Сайн ойлголтугүй | 14 | 6,1% | 6,1% |
| 5 | Нийт | 231 | 100,0% | 100,0% |

Урлагийн боловсролын талаарх мэдлэг мэдээлэл олон нийтэд маш их хэрэгцээтэй байгаа нь дээрх асуулгаас харагдаж байгаа бөгөөд 231 хүний 135 хүн буюу 58,4% нь маш их хэрэгтэй хэмээн хариулсан нь нийгэмд энэ талаар мэдлэг мэдээлэл, ойлголт дутмаг байгаа нь харагдаж байна.

Хэлэлцүүлэг

Монгол дахь цаг үеийн түүхэн явцыг харахад урлагийн боловсролын түгээмэл ойлголт нь олон нийтийн дунд ташуу байх боломжтой нөхцөлөөс үүдээд энэхүү ойлголтыг тодрууллаа. Дэлхий дахинд түгсэн урлагийн боловсролын ойлголт бүрэлдэхэд нөлөөлсөн гол гол бүтээл болон тухайн цаг үед нөлөөлсөн хүчин зүйлсийг судлан, монголд урлагийн боловсролын тухай ойлголт олон нийтэд хэрхэн түгсэн судалгааг багш, судлаач, эцэг эх зэрэг бүлгүүдээс авсан ба асуулгыг дэлхий дахинд хэрхэн үнэлж буй дөрвөн категорийн үндсэн дээр боловсруулав. Энэхүү судалгаагаар нийгэмд урлагийн боловсролын талаар ойлголт харьцангуй зөв байгаа нь харагдсан бөгөөд цаашид хэрхэн хүртээмжтэй хүргэж, өдөр тутмын амьдралд оруулж ирэх нь асуудалтай байгаа нь харагдсан.

Дүгнэлт

Судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь урлагийн боловсролын талаарх мэдлэг мэдээлэл дутмаг хангалтгүй, хэрэгцээ маш их байгаа бөгөөд хүүхэд бүрт системтэйгээр олгох боловсрол болон хүүхэд бүрт байх гоо зүйн төлөвшил хэмээн хариулсан нь судалгаанд оролцогчдын ихэнх нь урлагийн боловсролын тухай ойлголтыг зөвөөр ойлгодог болох нь харагдаж байна. Энэ нь бидний эхэнд тавьсан судалгааны таамаглал болох урлагийн боловсролын тухай 2-р түвшний ойлголттой гэх хандлагыг өөрчилж, нийт хүн амын төлөөлөл 3-р түвшний ойлголттой байгаа нь үнэхээр сайшаалтай байж таамаглалыг няцаалаа. Хэдий тийм ч үүнийг түгээн дэлгэрүүлэн судалж, олон нийтэд хүрэх ажил нь хангалтгүй байна. Урлагийн боловсрол системтэй олгох нэгдсэн нэг бодлого байхгүй ба дүрслэх урлагийн боловсрол, хөгжмийн боловсрол гэх мэт дор бүрнээ онцлогт урлагийн боловсролыг олон нийтэд олгох аргазүй хэрэгтэй. Хүүхэд бүрт өдөр тутамд хэрхэн урлагийн боловсрол олгох, таниулах тал дээр багш, эцэг эхэд мөн чиглүүлэг, уялдаа холбоотой заах аргазүй, систем хэрэгтэй болох нь харагдаж байна.

Энэ талаар бичигдсэн ном зохиол, судалгааны бүтээл ховор байгаа нь ажиглагдаж байна. Тиймээс багш нарыг чадавхжуулах, энэ талын судлаач нарыг бэлтгэх болон эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, урлагийн боловсрол олгож буй системийг дахин эргэн харж, агуулга болон хөтөлбөр дээр анхаарах шаардлагатай.

Урлагийн боловсрол системтэй хөгжсөн орнуудад урлагийн боловсролыг хүүхэд хөгжлийн салшгүй нэг хэсэг болгосноор ирээдүйн чанартай үзэгчийг бэлдэх суурь болж байна. Глоб интернейшнл урлагийн боловсролын 2003 оны судалгааны үр дүн нийгэмд урлагийн боловсролын ойлголт дутмаг байгаа гэж гарч байсан бол 21 жилийн дараа ч хүн бүрт хүрч буй хүртээмж хангалтгүй, урлагийн боловсролын байгууллага, хичээлийн хөтөлбөр дутмаг бөгөөд чанарын тал дээр анхаарах, урлагийн боловсролын хөтөлбөрийн чанарын судалгаа шаардлагатай хэмээн дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Angel E. Shectman and others. 1970. *Insights into Elementary Art Education for Teachers of Art*.
- Arthur D. Efland. 1990. *The History of Art Education*. New York: Teachers College Press.
- Charles D. Gaitskell. 1958. *Children and their art*. USA: Harcourt.
- Gabriela Robeci. 2017. "Art Education" *Art out online Magazine*.
- Liora Bresler. 2007. *International handbook of Research in Art education*. Netherlands: Springer.
- Terry Barret. 2000. "About Art interpretation for Art education" *Studies in Art education, Volume 42*.

Vojislav Пис. 2017. “Concept of art education curriculum, tendencies and challenges”
Journal of Subject Didactics

Ариунаа, Ш. 2018. “Урлаг судлал: Философи, онол арга зүйн асуудлыг шинжих нь.” *Монголын урлаг судлаачдын Форум I*. Ред. Энхцэцэг Д. Улаанбаатар.

Даваа, Ж. 2015. “Хүүхдийн гоо сайхны хөгжил боловсролын асуудалд” *Гоо зүйн боловсрол ба орчин үе*. Улаанбаатар.

Даваапил, П. 2013. “Дүрслэх урлагийн боловсролын хөтөлбөрт гарсан өөрчлөлт.”
Монголын соёл, урлаг судлал 16: 35-45.

Даваапил, П. 2018. *Урлаг судлалд*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэл.

Дэлгэрмаа, Б. 2022. “Монголын гоо зүйн боловсрол: Өчигдөр, өнөөдөр.” *Монголын соёл урлаг судлал* 42: 218-230.

Ган-Өлзий, Ч. 2022. “Хүмүүнлэг боловсролын философийн үндэслэгээ.” *Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага*. Улаанбаатар.

Пүрэв, О. 2022. “Боловсролын ёс зүй ба шинэ үеийнхний танин мэдэхүй, ёс суртахууны онцлог” *Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага*. Улаанбаатар.

Цахим эх сурвалж

Глоб Интернетшл ТТБ. 2004. “Урлагийн Боловсрол” судалгааны тайлан. <http://www.globeinter.org.mn/>.